

Нэхэмжлэгч З.Батсүлд нь Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2018 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар тус газрын Төрийн захиргаа, санхүү удирдлагын газрын Хууль эрх зүйн асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдож, 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Б/05 дугаар тушаалаар тус албан тушаалд томилогдон ажиллаж байсан бөгөөд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Б/69 дүгээр тушаалаар З.Батсүлдийг тус газрын Төрийн захиргааны удирдлагын газрын хууль, эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнээс 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөр тасалбар болгон ажил, албан тушаалаас чөлөөлж, Ховд аймгийн Мал эмнэлгийн газарт шилжүүлж, мөн өдрийн 01/1068 тоот албан бичгээр дээрх тушаалыг Ховд аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлж, нэхэмжлэгчийг ажлын байраар хангахыг үүрэг болгожээ.

Нэхэмжлэгч “Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Б/69 дугаартай “З.Батсүлдийг шилжүүлэн ажиллуулах тухай” тушаал нь Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажил албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын 1.2, 1.5, 1.6-д заасныг зөрчсөн мөн уг тушаалд нэхэмжлэгчийг ямар ажил албан тушаалд шилжүүлэн ажиллуулж байгааг бичээгүй, төрийн байгууллага нөгөө байгууллагатай тохиролцоогүй атлаа өөрийн ажилтныг шууд шилжүүлэн ажиллах тушаал гаргаж ажиллуулахыг үүрэг болгосны улмаас миний бие өнөөдрийг болтол хохирч байна” гэж,

Хариуцагчаас, “... Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт Агентлагийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.3.5-д “хууль тогтоомжид заасны дагуу албан тушаалд томилох, чөлөөлөх, албан тушаалаас бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, ...”, 8.4-д “Агентлагийн дарга энэ хууль болон холбогдох бусад хуулиар олгосон бүрэн эрхэд хамаарах асуудлаар тушаал гаргана” гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл Мал эмнэлгийн ерөнхий газрын даргаас хуулиар олгогдсон эрхийн хүрээнд шийдвэрээ гаргасан” гэх агуулгаар тус тус маргасан байна.